



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/719

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймгийн Дарви суманд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Эвлэл" ХК-ний гүйцэтгэсэн инженерийн хийцтэй худаг гаргах ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Г.Гончигсүрэн –Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд: Д.Ганбаатар -Аймгийн мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч

Л.Мөнхжаргал- Дарви сумын Засаг даргын Тамгын газрын дарга

М.Цогтэрдэнэ –Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

Д.Эрдэнэбат-Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн

У.Пүрэвдорж-"Эвлэл" ХК-ний захирал

Нарийн бичгийн дарга: Ц.Пүрэвсүрэн –Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2.Инженерийн хийцтэй худаг гаргах ажлыг зураг, төсвийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг улсын комиссын дарга /Г.Гончигсүрэн/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 03510

Zax A/719 Ch